


Очирл. М. Цамсцал

Аудит газрын дарга

М. Цамсцал

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Үндэсний аудитын газрыноныдугаар
сарынны өдрийндугаар гэрээний хавсралт



М. Цамсцал О.ТЭНГИС

**ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ
АЖЛЫН ДААЛГАВАР**

2020 оны 05 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар *УАА-2020/009А*

Улаанбаатар хот

ЗОРИЛГО:

“Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан зарим инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийн зураг төсөл, төсөвт өртөг болон ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилгын норм, дүрэм, стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

1. ҮНДЭСЛЭЛ:

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын сэдэв”-ийг үндэслэн “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Монгол Улсын Ерөнхий аудитор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гаднын шинжээч, мэргэжилтнийг аудитын үйл ажиллагаанд татан оролцуулж, үйлчилгээ, зөвлөгөө авч болно” гэж заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох эрх зүйгээр мэргэшсэн, ажлын туршлага бүхий зөвлөхийн багийг аудитад татан оролцуулах шаардлагатай байна.

2. ЗОРИЛТ:

Шинжээч нь 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон инженерийн шугам, сүлжээний барилга, байгууламжийн зураг төсөл нь зохих норм, журмын дагуу зохиогдсон эсэх, холбогдох төсөв нь бодитой, үнэн зөв тооцоологдсон эсэх, барилга угсралтын ажил нь холбогдох зураг, төсвийн дагуу чанартай хийгдсэн эсэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргаж, холбогдох зөвлөмж боловсруулна.

3. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖИЛБАРУУД:

Шинжээч нь улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжсэн инженерийн шугам, сүлжээний байгууламжийн төсөл, арга хэмжээний батлагдсан зураг төсөл, төсөв болон ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах ажлыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1. Инженерийн шугам, сүлжээний барилга байгууламжийн зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангаж, төлөвлөлт, судалгаанд үндэслэсэн эсэхэд шинжээчийн дүгнэлт гаргах;
- 3.2. Инженерийн шугам, сүлжээний барилга, байгууламжийн төсөв нь батлагдсан зураг төслийн дагуу холбогдох хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиогдож, хянагдаж магадлалаар баталгаажсан эсэхэд дүгнэлт гаргах;
- 3.3. Инженерийн шугам, сүлжээний барилга байгууламжийн суурь, бүтээц, угсралтын ажил зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргана. Үүнд:
 - Геодезийн эрх бүхий зөвшөөрөлтэй компаниар тэг тэнхлэг (Улаан шугам) тавиулж мэдээллийн санд шугамын трассыг оруулсан эсэх,
 - Гэрээ байгуулснаас хойш ажил дуусах хугацаанд хийгдэх ажилбаруудын нарийвчилсан төлөвлөгөө гарган баталгаажуулсан эсэх,
 - Шугам сүлжээний барилга угсралтын ажлыг эхлүүлж, үргэлжлүүлэх технологийн зогсолт хийх горим стандартыг мөрдөн ажилласан эсэх,
 - Батлагдсан зурагт заасны дагуу тоног төхөөрөмж, материалын таталтыг хийн, угсарсан эсэх,
 - Шугам сүлжээний газар шорооны ажил батлагдсан зургийн трассын дагуу хийгдсэн эсэх,
 - Шуудуунд элсэн дэвсгэр хийн, ус чийгээс хамгаалах хамгаалалт хийсэн эсэх,
 - Технологийн дагуу зургийн дагуу худгийг барьсан эсэх,
 - Шугам хоолойг сувагт зургийн дагуу байршуулж гагнан, гагнуурын баталгаа лабораторийн дүгнэлт гаргасан эсэх,
 - Шугам хоолойн угсралтын ажил болон худгийн ажил, хаалт арматур, тоног төхөөрөмжүүд угсарсны дараагаар шугам сүлжээг бүхэлд нь шахаж шалган, ил далд ажлын акт үйлдэж баталгаажуулсан эсэх,
 - Батлагдсан зургийн дагуу шугамын налуууг шалган, холболтыг стандарт технологийн дагуу хийсэн эсэх,
 - Сувагт таг тавин эргэн булалт хийн хөрсийг нягтаршуулж, нөхөн сэргээлт, тохижилтын ажлыг зургийн дагуу хийсэн эсэх,
 - Шугам хоолойн угсралтын ажилд өөрчлөлт орсон бол зохиогчийн зөвшөөрөл авсан эсэх,
 - Гүйцэтгэлийн зураг гаргаж баталгаажуулсан эсэх,
 - Уг төсөл арга хэмжээний гүйцэтгэлд технологийн зөрчил гаргасан эсэх.
- 3.4. Барилга байгууламжийн гадна орчны тохижилтын ажил зураг төслийн дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах;
- 3.5. Барилга байгууламжийн угсралтын үе шатны ажлуудад захиалагчийн техникийн, зохиогчийн хяналтыг зохих ёсоор гүйцэтгэсэн эсэх, өгсөн зааварчилгааг хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгаж, дүгнэлт гаргах;
- 3.6. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комисс ажилласан бол тэдгээрээс өгсөн үүрэг даалгавар хэрэгжилтэд дүгнэлт гаргах;
- 3.7. Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад материалын тоо хэмжээ, орц, нэр төрөл, чанар, агууламж зэргийн хувьд батлагдаж, хянагдсан төсөв болон бодит гүйцэтгэл зөрүү илэрсэн бол тэдгээрийн гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх

нөлөөллийг тогтоож, барилга угсралтын явцад төсөвт гарсан хэмнэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах.

4. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Шинжээч нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн хавсралтад дурдсан нэр бүхий инженерийн шугам, сүлжээний байгууламжид дүгнэлт гаргана.

5. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН:

Шинжээч нь ажлын даалгаварт тусгагдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, гэрээт ажлын хүрээнд хамрагдсан барилга, байгууламжийн зураг төсөл, төсөвт өртөг нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, норматив, стандартаар тавигдах бусад шаардлагуудыг хангасан эсэх, техникийн шаардлагын дагуу баригдсан эсэхийг хянан үзэж мэргэжлийн дүгнэлт гаргаж, үр дүнг тусгасан шинжээчийн тайланг төсөл, арга хэмжээ бүрээр бэлтгэнэ.

Шинжээчийн тайланд дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийг учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

6. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх хуулийн этгээд /түншлэл/ болон тус хуулийн этгээдийн ажиллуулах шинжээчид нь Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын баг бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.

Ажлын даалгаварт тусгагдсан ажлын гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээд нь ажил эхлүүлэх, ажлын явцад үүсэх хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор захиалагч Үндэсний аудитын газар /Гүйцэтгэлийн аудитын газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

7. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

Шинжээч нь аудитын талбарын үе шатнаас эхлэн тайлагналын үе шат дуусах хүртэл хугацаанд хариуцсан асуудлаар аудитын багт мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

Эхлэх хугацаа: 2020 оны 3 дугаар сарын 01-ний өдөр

Дуусах хугацаа: 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдөр

8. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Шинжээч хуулийн этгээд нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хүрээнд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл, төсөв боловсруулах, магадлал хийх, дүгнэлт гаргах эрх бүхий, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, эдийн засгийн үр өгөөжийг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн, техникийн үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага, туршлагатай хуулийн этгээд байна.

Шинжээчээр ажиллах хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан боловсон хүчинтэй байна. Үүнд:

- Ус хангамж болон ариутгах татуургын инженер;
- Ус хангамж болон ариутгах татуургын зураг төсөл боловсруулах чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан, ажлын дадлага туршлагатай, зөвлөх инженер;
- Ус хангамж болон ариутгах татуургын барилга угсралтын чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан ажлын дадлага туршлагатай, зөвлөх инженер;
- Ус хангамж болон ариутгах татуургын барилга байгууламжийн төсөв зохиох, хянах, магадлал хийх эрхтэй, тэргүүлэх зэрэгтэй төсөвчин, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, ажлын дадлага туршлагатай байх.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

9. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

Хянасан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНГЭРЭЛ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЕНЕЖЕР



4/13

Н.АНХБАЯР

Самал гаргасан.

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.САРУУЛ

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР



Б.БАТДЭЛГЭР

АУДИТОР

Ж.ОЮУНТУЯА

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн шинжээчийн дүгнэлт гаргах инженерийн байгууламжийн төсөл, арга хэмжээний жагсаалт

№	ТЕЗ	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Байршил		Хугацаа		Төсвийн тухай 2019 оны хуулиар		Шинжээчийн зардалд төсөвлөсөн
				Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	
1	БХБС	XI.1.8	Инженерийн шугам сүлжээ /Баянцагаан баг/	Орхон	Баян-Өндөр	2018	2020	3,400.0	9006.109 902,2400.0 396	4.8
2	БХБС	XI.1.10.1	"Нийслэл, аймгийн төвийн орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ /нийслэл, 21 аймаг/ төсөл, арга хэмжээ"-ний хүрээнд хийгдсэн: Төв аймгийн Зуунмод хотын 2*2000м3 багтаамжтай усан сан, усан хангамжийн шугам сүлжээний ажил	Төв	Зуунмод	2018	2019	2,800.0	2,800.0	3.6
3	БХБС	XI.1.10.2	"Нийслэл, аймгийн төвийн орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ /нийслэл, 21 аймаг/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдсэн: 5.5 км цэвэр ус, 2.0 км ариутгах татуургын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл	Сүхбаатар	Баруун-Урт	2018	2019	1,682.0	1,682.0	2.4
4	БХБС	XI.1.10.3	"Нийслэл, аймгийн төвийн орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ /нийслэл, 21 аймаг/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдсэн: Чингис хотын 4160м цэвэр усны шугам шинэчлэл	Хэнтий	Хэрлэн	2018	2019	904.4	904.4	2.0
5	БХБС	XI.1.10.4	"Нийслэл, аймгийн төвийн орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ /нийслэл, 21 аймаг/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдсэн: Даралттай бохир ус зайлуулах шугам, I ба II баг хороог болон усны эх үүсвэрүүдийг холбох цэвэр усны шугам, гүний худгуудийн гадна, дотор цахилгаан автоматжуулалтын угсралт, гүний худаг гаргах барих	УБ	Багахангай	2019	2019	1,742.0	1,742.0	2.5
6	БХБС	XI.1.11.1	Нийслэл, аймгийн төвүүдийн үерийн хамгаалалтын шинэчлэлт, зураг төсвийн хамт /улсын хэмжээнд/ ТАХ-ний хүрээнд: 2, 7 дугаар багийн үерийн хамгаалалтын далан сувгийн ажил	Баянхонгор	Баянхонгор	2018	2020	3,000.0	3,000.0	3.9
7	БХБС	XI.1.11.2	Нийслэл, аймгийн төвүүдийн үерийн хамгаалалтын шинэчлэлт, зураг төсвийн хамт /улсын хэмжээнд/ ТАХ-ний хүрээнд: Үерийн далан байгууламж барих /ажлын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил/	Дундговь	Мандалговь	2018	2019	1,424.0	1,424.0	2.8
8	БХБС	XI.1.45	Гэр хорооллын айл, өрхүүдийн цэвэр, бохир, дулааны шугам /7, 8, 9, 10, 11 дүгээр хороо, Шинэ хороо төсөл/	УБ	ЧД	2019	2019	1,500.0	1,500.0	3.0
НИЙТ ДҮН								16,452.4	15,452.4	25.0

Шинжээч ажиллуулах зардал 25.0 сая төгрөг